

ТӨВ БОЛОН ЗҮҮН ЕВРОП СУДЛАЛЫН МОНГОЛЫН ХОЛБОО БАЙГУУЛАГДАВ

Олон улс судлалын хүрээлэнгийн /ОУСХ/ Орос судлалын салбар, Герман судлалын төвийн судлаачдын санаачилгаар Европ болон слав судлалын чиглэлээр судалгаа хийж сургалт явуулдаг эрдэмтэд, их дээд сургуулийн багш нар, тухайлбал МУИС ийн Олон улсын харилцааны сургуулийн Дипломат орчуулгын тэнхим, Олон улсын эдийн засгийн харилцааны тэнхим, МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн Слав судлалын тэнхим, МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн Сэтгүүл зүйн тэнхим, мөн сургуулийн Нийгэм-соёлын антропологийн тэнхим, МУБИС-ийн Дэлхийн түүхийн тэнхим зэрэг байгууллагуудын төлөөлөл хамтран оролцож Төв болон Зүүн Европ судлалын Монголын холбоог байгуулав.

Энэхүү холбооны үүсгэн байгуулагчдын хурал 2012 оны 11-р сарын 14-ний өдөр ОУСХ-ийн байранд болж 20 гаруй хүн оролцов. Тус хурлын эхэнд Төв болон Зүүн Европ судлалын дэлхийн холбооны танилцуулга, дүрэм, гишүүнчлэл, үйл ажиллагааны зорилго чиглэл, зохион байгуулдаг хурал бусад арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл сонсож, Монголд шинээр байгуулагдах Холбооны зорилгын тухай болон дүрмийн төслийг хэлэлцэв. Үүсгэн байгуулагчид байгууллага дэлхийн холбоотой ижил нэрээр буюу Төв болон Зүүн европ судлалын холбоо гэж нэрлэхээр тогтов. Холбооны дүрмийг баталж, удирдлагыг сонгож батлав.

Холбооны тэргүүнээр ОУСХ-ийн захирал доктор\Sc\, проф. Л.Хайсандай, дэд тэргүүнээр МУИС-ийн ГХСС-ийн Слав судлалын тэнхимийн эрхлэгч дэд проф. Н.Нансалмаа нарыг сонгож батлав. Мөн Удирдах Зөвлөлийг 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Хяналтын Зөвлөлийн даргаар МУИС-ийн ОУХС-ийн Дипломат орчуулгын тэнхимийн багш доктор\Sc\ Ц.Саранцацрал, Гүйцэтгэх захирлаар ОУСХ-гийн Орос судлалын секторын ЭШААжилтан доктор \PhD\ Д.Алтай, Нарийн бичгийн даргаар ОУСХ-гийн ЭША Х.Мандухай нарыг тус тус сонгож батлав.

Тус Холбоо Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, нийгэмд үйлчилдэг ТББ-ын статустай хуулийн этгээд болсноор албан ёсоор үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдлээ. Холбооны гол зорилго нь Монгол Улсад Төв болон Зүүн Европ судлалын асуудлаар судалгаа шинжилгээ хийх, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах, мэдээлэл солилцох, эрдэм шинжилгээний болон танин мэдэхүйн сэтгүүл гаргах, сурталчилгаа хийх, залуу судлаачдыг дэмжих, гадаад дотоодын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах явдал юм. Түүнчлэн Төв болон Зүүн Европ судлалын Олон улсын холбоонд гишүүнээр элсэх, түүний үйл ажиллагаанд идэвхтэй оролцох зорилготой юм.

1974 онд байгуулагдсан Төв болон Зүүн Европ судлалын Олон улсын холбоонд International Council for Central and East European Studies \ICCEES\

эдүгээ 57 орны 1250 гаруй судлаачид хамрагддаг ба Ерөнхийлөгчөөр нь Австрали Улсын Сиднейн Их сургуулийн профессор Грэм Жийл ажилладаг ба Удирдах Зөвлөлийг тэргүүлдэг. Олон улсын холбоо нь 5 жилд нэг удаа их хурал \Congress\ зохион байгуулдаг бөгөөд эдүгээ хүртэл 8 удаагийн их хурлыг хийжээ. Энэ холбооны ээлжит 9 дэх их хурал анх удаа Ази тивд 2015 оны 8-р сард болох гэж байгаагаараа онцлог юм. Энэ ч утгаараа 2013 оны 8-р сард Японы Осака хотноо зохион байгуулагдах Зүүн Азийн Слав болон Евроази судлаачдын 5 дахь удаагийн бага хурлын бэлтгэл ажлын хүрээнд Ази тивээс олон орны судлаачдыг Холбоондоо татан оролцуулах, гишүүн орнуудын эгнээг өргөжүүлэх хүсэлтэй байгаа юм.

Тухайлбал, Төв болон Зүүн Европ судлалын Олон улсын холбоонд Ази тивээс идэвхтэй оролцдог Японы эрдэмтэд жишээлбэл, Хоккайдо Их Сургуулийн слав судлалын төвийн профессор доктор Кимитака Мацузато 2012 оны 11-р сард ОУСХ-гээс эрхлэн Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Монгол-Оросын 1912 оны гэрээ ба И.Я.Коростовец” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцож “Ази маягийн Орос: Геополитик ба газар нутгийн менежмент” сэдвээр сонирхолтой илтгэл тавьсан бөгөөд энэ үеэр Монголын эрдэмтэн судлаачидтай уулзаж, Төв болон Зүүн Европ судлалын Олон улсын холбооны тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн билээ. Доктор К.Мацузато тус Холбооны дэд Ерөнхийлөгчийн сонгуультай бөгөөд монгол судлаачид нь Европ судлал ялангуяа Орос судлалаар багагүй туршлага хуримтлуулсан, эрдэм шинжилгээ судалгааны болон сургалтын ажлын чадавхитай гэдгийг харгалзан энэхүү саналыг бидэнд тавьсан юм. Монголын эрдэмтэн судлаачдын хувьд ч олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, мэдээлэл солилцох, залуу эрдэмтдийг дэмжин арга зүй туршлагаас хуваалцах, олон улсад түгээдэг сэтгүүлд бүтээлээ хэвлэн нийтлүүлэх, дэлхийн болон бүс нутгийн их хурал, бага хурал, семинарт оролцож, илтгэл мэдээлэл тавих хэрэгцээ шаардлага байгаа юм.

Тиймээс энэхүү санал санаачилгыг Монголын эрдэмтэн судлаачид, багш нар талархалтай хүлээн авч Төв болон Зүүн Европ судлалын Монголын холбоог байгуулж Дэлхийн холбоонд гишүүнээр элсэх хүсэлтээ гаргаад байна.

Төв болон Зүүн Европ судлалын Олон улсын холбоо /ICCEES/ нь дэлхийн түвшинд гишүүн байгууллага холбоодын оролцоотойгоор сүлжээ байгуулан 5 жилд нэг удаа их хурал зохион байгуулдаг, их хурлын завсар чөлөөнд бүс нутгийн бага хурлыг хийдэг байна. Мөн жилд 2 удаа сэтгүүл Newsletter-ийг хэвлэн гаргадаг. Түүнчлэн гишүүн байгууллага холбоодын эрдэмтэн судлаачид мэдээлэл солилцох, залуу судлаачдыг дэмжих чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг байна.

Энэхүү Холбооны гишүүнээр АНУ, Грек, Итали, Австрали, Шинэ Зеланд, Бельги, БНХАУ, Англи, Канад, ХБНГУ, Голланд, Финлянд, Франц, Ирланд, Израиль, Япон БНСУ, Швед зэрэг орны эрдэм шинжилгээний төв, холбоод, дагалдах гишүүнээр Испани, ОХУ, Польш, Чех Улсын эрдэмтэн судлаачид

хамрагдан ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд Холбооны үйл ажиллагааны хамрах хүрээ өргөжсөөр байна. Тухайлбал 2000 онд Финлянд Улсын Тампере хотод болсон дэлхийн 6-р их хуралд 47 орны 1829 судлаачид оролцсон бол 2010 онд Шведийн Стокгольм хотноо болсон 8-р их хуралд 57 орны 1247 эрдэмтэн судлаачид оролцжээ.

Төв болон Зүүн Европ судлалын дэлхийн эрдэмтэд 2015 онд Японы Макухарид 9-р их хурлаа хийх гэж байна. Өмнөх хурлууд Европ тивд ээлж дараалан хуралдаж байсан бол 2015 онд анх удаа Ази тивд болох гэж байна.

Төв болон Зүүн Европ судлалын Монголын холбоо 2013 онд Олон улсын холбоонд гишүүнээр элсвэл гадаад харилцаа эрс өргөжин, судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ өргөжиж, мэдээлэл солилцох, гадаадын шилдэг эрдэмтдээс арга зүй, туршлагаас суралцах, залуу судлаачдын сонирхлыг татан тэднийг дэмжих шинэ боломж бололцоо нээгдэх юм.

Мэдээ бэлтгэсэн Д.Алтай